



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/1046

Улаанбаатар хот

“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “а”, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Эмээлтийн Хөнгөн Үйлдвэрийн Үйлдвэрлэл, Технологийн Парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулах 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, Технологийн парк” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.
2. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, Технологийн Парк” орон газрын нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог хавсралтаар заасан тооны хязгаарт багтаан ажилтан ажиллагсдын тогтмол цалин хөлс, нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоож ажиллахыг “Эмээлтийн Хөнгөн Үйлдвэрийн Үйлдвэрлэл, Технологийн Парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /М.Гончигжав/-т үүрэг болгосугай.
3. “Эмээлтийн Хөнгөн Үйлдвэрийн Үйлдвэрлэл, Технологийн Парк” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын даргатай контрактын гэрээ байгуулж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т даалгасугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ

Н.БАТАА

111020004511

Нийслэлийн Засаг даргын 2014 оны
12 дугаар сарын *19*-ны өдрийн
А/1046 дугаар захирамжийн хавсралт



“ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэрс	Тоо
1	Дарга	1
2	Төслийн зохицуулагч	1
3	Үйл ажиллагаа, хүний нөөцийн менежер	1
4	Эрх зүйч	1
5	Нягтлан бодогч	1
6	Хөрөнгө оруулалтын менежер	1
7	Эдийн засагч	1
8	Инженер	5
9	Жолооч, нярав	1
10	Нийт	14